



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/41

Чингис хот

Улсын нөөцийн өвсийг олгох болон
аюулгүй нөөцийн өвсийг худалдан борлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын №02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 212 дугаар тогтоолын дагуу 100 тн буюу 5000 боодол өвсийг өвөлжилт хүндэрсэн сумдад хуваарь гарган олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /ЖЭнх-Амгалан/-т даалгасугай.

2. Аймгийн аюулгүйн нөөцөд бэлтгэсэн 2020 оны өвсийг малчдад нэг бүрийн үнийг 10.000 төгрөгөөр тооцож, сумдын Засаг дарга нартай зөвшилцөн хуваарь гарган борлуулахыг Орон нутгийн өмчийн газар /Л.Батсайхан/-т, борлуулсан өвсний үнийг аймгийн 100180051414 тоот дансанд төвлөрүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010129